



## НИЙГМИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ТҮҮНИЙ СЭТГЭЛ ЗҮЙН ҮНДЭС

## THE PSYCHOLOGICAL FOUNDATIONS OF SOCIAL DISCRIMINATION AND EXCLUSION

Батсайханы Уянга<sup>1</sup>

*University of Internal Affairs, Mongolia, E-mail: uyangabatsaikhan18@gmail.com*

### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

#### **Түлхүүр үгс:**

ялгаварлан гадуурхах үйлдэл,  
үзэн ядалт, ялгаварлан  
гадуурхах гэмт хэрэг, эс  
үйлдэхүй

#### **Нийтлэлийн түүх:**

Хүлээн авсан: 2026, 03 сар  
Шинэчилсэн: 2026, 03 сар  
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04  
сар

#### **Keywords:**

*Discriminatory act, Hatred,  
Crime of discrimination,  
Omission.*

#### **Article history:**

Received March, 2026  
Revised March, 2026  
Accepted April, 2026

### ХУРААНГУЙ

“Нийгмийн ялгаварлан гадуурхалт ба түүний сэтгэл зүйн үндэс” сэдэвт илтгэлд нийгмийн ялгаварлан гадуурхалтын мөн чанар, түүний хувь хүний сэтгэлзүйд үзүүлэх нөлөө, түүнээс урган гарах сэтгэлзүйн механизм, мөн сөрөг үр дагаврыг бууруулах арга замуудыг судлан авч үзсэн. Илтгэлд ялгаварлан гадуурхалтын төрөл, илрэх хэлбэр, түүнтэй холбоотой стресс, сэтгэл гутрал, айдас, өөрийгөө үнэлэх үнэлэмжийн бууралт зэрэг сэтгэлзүйн өөрчлөлтүүдийг онолын болон судалгааны жишээн дээр тайлбарласан. Мөн нийгмийн болон сэтгэлзүйн дэмжлэг нь ялгаварлан гадуурхалтын сөрөг нөлөөг бууруулах чухал хүчин зүйл болохыг тодотгож, боловсрол, бодлого, хувь хүний түвшинд хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг дэвшүүлсэн. Энэхүү судалгааны үр дүн нь нийгэмд эрх тэгш, сэтгэлзүйн хувьд эрүүл орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр болох зорилготой юм.

**Abstract:** The presentation titled “Social Discrimination and Its Psychological Basis” explores the nature of social discrimination, its impact on individual psychology, the underlying psychological mechanisms, and strategies to reduce its negative consequences. It discusses different types and manifestations of discrimination, as well as related psychological effects such as stress, depression, fear, and decreased self-esteem, supported by theoretical perspectives and research findings. The study emphasizes that social and psychological support play a crucial role in mitigating the adverse impacts of discrimination. Furthermore, it proposes recommendations and strategies to be implemented at the educational, policy, and individual levels. The results of this study aim to contribute to the creation of an equitable and psychologically healthy social environment.

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



<sup>1</sup>Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш

## 1. Танилцуулга

Орчин үеийн нийгэмд ялгаварлан гадуурхалт нь хүний эрх, нийгмийн шударга ёс, сэтгэлзүйн эрүүл мэндтэй салшгүй холбоотой чухал асуудлын нэг болж байна. Энэхүү үзэгдэл нь арьс өнгө, хүйс, нас, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, нийгмийн гарал угсаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан илэрдэг бөгөөд хувь хүний нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмж, харилцаанд шууд нөлөөлдөг.

Сэтгэлзүйн үүднээс авч үзвэл ялгаварлан гадуурхалт нь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, нийгмийн харьяаллын мэдрэмж, аюулгүй байдлын итгэлцэлд хүчтэй дарамт үзүүлдэг. Хүн нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх, бусдаар хүндлэгдэх, шударгаар хандагдах хэрэгцээтэй байдаг тул ялгаварлагдах нь гүнзгий сэтгэлзүйн гэмтэл, айдас, түгшүүр, сэтгэл гутрал үүсгэх шалтгаан болдог байна. Энэхүү илтгэл нь нийгмийн ялгаварлан гадуурхалтын шалтгаан, илрэх хэлбэр, хүний сэтгэлзүйд үзүүлэх нөлөө болон сэтгэлзүйн үндсийг шинжилж, үүсэх сөрөг үр дагаврыг бууруулах арга зам, нийгмийн дэмжлэгийн ач холбогдлыг тодорхойлох зорилготой юм. Илтгэлд сэтгэлзүйн онолын хандлагууд, судалгааны жишээ, бодит өгөгдөлд тулгуурлан хүний сэтгэлзүйн хамгаалалтын механизм, нийгмийн орчны үүргийг хамтатган авч үзсэн болно.

## 2. Арга зүй

Судалгаанд нийгмийн ялгаварлан гадуурхалтын талаарх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, сэтгэл судлалын онол, судалгааны үр дүнг нэгтгэн шинжлэх замаар баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан судалгааны болон агуулгын шинжилгээний аргыг хэрэглэв.

## 3. Судалгааны үр дүн

### Нэг. Ялгаварлан гадуурхах үйлдэл ба түүний сэдэлт

Нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг ялгаварлан гадуурхалт гэж тодорхойлдог байна. Боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт, бүх төрлийн үйлчилгээ авахад ямар нэг нийгмийн бүлэгт харьяалагдах мөн чанараар нь буюу үндэс, шашин, үндэс угсаа гэх мэт хүчин зүйлсээр хүмүүсийг ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайн хүнийг эрхээ эдлэх тэгш боломж олгохгүй байхыг хэлдэг<sup>2</sup> хэмээн тодорхойлжээ.

Ялгаварлан гадуурхах үйлдэл гэдэг нь нийгмийн тодорхой бүлгийн гишүүний хувьд бусад хүмүүстэй адил эрх тэгш хандахгүй байхыг хэлнэ<sup>3</sup>. Энэ нь боловсрол, ажил хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээ авах зэрэг олон талбарт тухайн хүнийг нийгмийн бүлэгт харьяалагдах, үндэс, шашин, үндэс угсаа гэх мэт хүчин зүйлээр ялгаварлан гадуурхах хэлбэрээр илэрч, хүний эрх тэгш боломжийг хязгаарладаг. Бусдыг ялгаварлан гадуурхах нь ихэвчлэн хувь хүний дургүйцэл эсвэл үзэн ядах сэдэлттэй холбоотой байдаг.

---

<sup>2</sup> Монгол улсын их хурлын цахим сайт. <https://www.parliament.mn/>

<sup>3</sup> Ю.Бадамханд “Хүүхдийн эсрэг гэмт явдал”. Уб., 2014 он, хуудас 32

Үзэн ядалт гэдэг нь латин гаралтай “Odium” гэсэн үг бөгөөд хүн рүү дайсагнах, дургүйцэх мэдрэмж болон түүний илэрхийллийг илтгэдэг. Үзэн ядалт нь хүнд хор хөнөөл учруулах боломжтой бөгөөд зарим тохиолдолд хүний амь насанд ч заналхийлж болзошгүй. Монгол Улсын Эрүүгийн хуульд үзэн ядалтыг гэмт хэргийн сэдэлт гэж тодорхойлсон бөгөөд зарим үйлдлийг “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт хамааруулсан байдаг<sup>4</sup>.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг нь:

1. Үндсэн гэмт хэрэг – Эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл.
2. Ялгаварлан гадуурхах сэдэлт – Хохирогчийг тодорхой нийгмийн бүлэгт харьяалагдах үндсэн мөн чанараар нь (үндэс угсаа, шашин, хэл, хүйс, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, мэргэжил гэх мэт) ялгаварлан гадуурхах сэдэлттэй үйлдэл.

Ийм байдлаар ялгаварлан гадуурхах нь хувь хүний үзэл бодол, сэтгэл хөдлөлийн илрэлээс эхлээд хууль эрх зүйн зохицуулалт хүртэл олон талаас хамаардаг гэдгийг харуулж байна.

### **Хоёр. Олон улсын хэм хэмжээ, хүний эрх, ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль эрх зүйн орчин**

Олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхалтыг хориглох олон хууль, конвенц, тунхаглал батлагдсан байдаг. Эдгээр нь аливаа иргэн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, тэгш боломжийг хангах үндсэн үүрэгтэй<sup>5</sup>. Тэдгээрээс жишээ болгон дурвал

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966)
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1965)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (2006)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990)
- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)
- Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц (1958)
- Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц (1960)
- Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986)
- Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг олон улсын хүний эрхийн эрх зүйд ашиглах тухай Жогжакартагийн зарчим (2006)
- Хүний эрхийн боловсрол, сургалтын талаарх тунхаглал (2011)

№	Олон улсын пакт	Үзэл санаа
---	-----------------	------------

1	Хүүхдийн эрхийн	Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль
---	-----------------	--

<sup>4</sup> Монголын хуульчдын холбооны цахим сайт. [https://www.mglbar.mn/a/4047#\\_ftnref3](https://www.mglbar.mn/a/4047#_ftnref3)

<sup>5</sup> Монголын хуульчдын холбооны цахим сайт. [https://www.mglbar.mn/a/4047#\\_ftnref3](https://www.mglbar.mn/a/4047#_ftnref3)

	тухай конвенц	ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй энэхүү Конвенцод заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана.
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно
3	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	Энэхүү Конвенцод “арьс үндсээр алагчлах” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон нийгмийн амьдралын бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг тэгш хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, үгүйсгэх зорилго бүхий арьс үндэс, арьсны өнгө, ураг төрөл, үндэсний буюу угсаатны гарал үүслийн үндсэн дээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу дээрд үзэхийг хэлнэ.
4	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	Энэхүү Конвенцын зорилгоор “эмэгтэйчүүдийг алагчлах” гэсэн нэр томъёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ.

**Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн “жендерт суурилсан хүчирхийлэл”-ийн тодорхойлолт**

Эмэгтэй хүн, охин, эрэгтэй хүн эсвэл хөвгүүний эсрэг үйлдсэн, тухайн хүндээ бие махбодын, бэлгийн, сэтгэлзүйн эрүүл мэнд, хөгжил, эсвэл түүний илэрхийлэлд нь сөрөг үр дагавар үүсгэсэн аливаа хор хөнөөл эсвэл шаналал. Хүчирхийллийн шалтгаан нь жендерт суурилсан эрх мэдлийн тэгш бус байдал, жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй байна.

**НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал,**

**Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, тэмцэх тухай Станбулын конвенц дахь “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” (ЭЭХ)-ийн тодорхойлолт**

1) Хүний эрхийн зөрчил 2) Ялгаварлан гадуурхсан үйлдэл 3) Эмэгтэй хүнд биемахбодын, бэлгийн эсвэл сэтгэлзүйн хор хөнөөл, шаналлыг албадах, эрх чөлөөг нь хязгаарлах зэрэг аюул заналхийлсэн үйлдлийг оролцуулан нийтэд илээр, мөн хувийн амьдралд нь эсэхээс үл хамааран нэгэнт учруулсан, эсвэл учруулахуйц шинжтэй хүчирхийлсэн үйлдэл

**НҮБ-ын “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл”-ийн тодорхойлолт**

Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын эрх мэдлийн тэгш бус түүхэн харилцааны илрэл нь эрчүүд эмэгтэйчүүдийг дарангуйлах, ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн хөгжихөд саад болдог ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээр дамжуулан эрэгтэйчүүдийн дор туслах байр сууринд эмэгтэйчүүдийг аваачдаг нийгмийн ноцтой механизмуудын нэг

***Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн үндэсний хэм хэмжээ***

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрхийг дээдлэн, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг тунхагласан тухай доктор, профессор Б.Чимид тайлбарлахдаа "Хүнийг дээдэлж, түүний эрх, эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм." Хүний эрх, эрх чөлөөг зөвхөн Үндсэн хуульд тодорхойлсон томъёоллоор хязгаарлан ойлгож, судалж, үнэлж, хамгаалж болохгүй. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд авч үзвэл зохино" гэж үзсэн<sup>6</sup>.

***Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван дөрөвдүгээр зүйл.***

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна<sup>7</sup>.

***Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах***

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

<sup>6</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017. 56, 194 дэх тал

<sup>7</sup> Монгол улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1. 14 дүгээр зүйл.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.бүлэглэж;

2.2.хүч хэрэглэж;

2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ<sup>8</sup>.

#### Ялгаварлан гадуурхах эс үйлдэл

Тодорхой хувь хүнийг мөн чанараар нь ялгаварласны улмаас эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол гэмт хэрэгт тооцогдож байна. Эс үйлдэхүйгээр ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаар заасан<sup>9</sup> боловч энэ үүргээ биелүүлэхгүй байх зэргийг тодорхойлсон байна.

#### Гурав. Нийгмийн ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд

Бодит нөхцөл байдалд бусдыг ялгаварлан гадуурхах үйлдэл, хандлага, үг хэллэг зэрэг хүмүүсийн илэрхийлэл түгээмэл байгаа нь нууц биш. Манайд түгээмэл үйлдэгддэг ялгаварлан гадуурхалтын төрөл<sup>10</sup>:

1. Бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхах /бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа өөр хүмүүсийг доромжлох, төрийн албан хаагчдын ялгаварлан гадуурхах хандлагаас айж гэмт халдлагад өртсөн ч гомдол гаргаж чаддаггүй/

2. Жендерийн ялгаварлан гадуурхалт / ихэнхдээ эмэгтэйчүүдийг сул дорой эсвэл эрчүүдээс доогуур гэж үзэх хандлага/

3. Хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалт /50-иас дээш настай хүмүүсийг хөгшин гэж үзэн ажилд орох боломжийг нь бууруулдаг/

4. Цалин хөлсний ялгаварлан гадуурхалт / Статистикийн хорооноос гаргасан мэдээнээс авч үзвэл 2021 оны байдлаар дундаж цалин эрэгтэйчүүдийнх 1.4 сая, эмэгтэйчүүдийнх 1.2 сая төгрөг, Оюутолгойн монгол ажилчид сард 2-5 сая гадаад ажилчид 20-40 саяын цалин авдаг гэх мэдээлэл/

5. Гадаад төрхөөр ялгаварлан гадуурхах /царайны төрх, таргалалт г.м байдлаас болж бусдын доог тохуу болох/

6. Хөгжлийн бэрхшээл, өвчний улмаас ялгаварлан гадуурхах / Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр дэлхийн хамгийн гадуурхагдсан бүлгүүдийн нэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Тахир дутуу хүмүүсийг бие махбод бус нийгмээр хязгаарладаг гэж үздэг. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар НХХЯ-наас судалж үзэхэд 13 яамд хөгжлийн бэрхшээлтэй 8 хүн ажилладаг бөгөөд 6 яам хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаггүй

<sup>8</sup> Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2015. №07. 14 дүгээр зүйл

<sup>9</sup> Хөдөлмөрийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2021. №31. 111 дүгээр зүйл

<sup>10</sup> Монголын хуульчдын холбооны цахим сайт. [https://www.mglbar.mn/a/4047#\\_finref3](https://www.mglbar.mn/a/4047#_finref3)

гэжээ. Хот дотор тэргэнцэртэй хүмүүс нийтийн тээврээр зорчих ямар ч нөхцөл бүрдээгүй буюу тусгай тоноглолтой автобус байхгүй мөн эдгээр хүмүүс барилга байгууламжийн орчинд нэвтрэх боломж хязгаарлагдмал байна/

7. Шашны ялгаварлан гадуурхалт / Шашны итгэл үнэмшил, тэдгээрээс улбаатай зан заншлын хувьд хүнийг гутаан доромжлох /

8. Хэлний ялгаварлан гадуурхалт / Хувь хүн эсвэл нийгмийн бүлгийг тэдний хэл яриа, аялга, аялгууны улмаас доромжлох/

9. Эдийн засгийн ялгаварлан гадуурхалт / Энэ нь хүмүүсийн хооронд мөнгө эсвэл эд хөрөнгийн хэмжээгээр ялгааг бий болгодог бөгөөд нийгмийн анги давхаргад үндэслэн ялгаварлан гадуурхахад хүргэдэг/

10. Нийгмийн давхаргаар ялгаварлан гадуурхах / Энэ нь тодорхой хувь хүмүүсийг нийгэмд авч болох ашиг тусаар нь ялгаж гадуурхдаг. Эдийн засаг, нийгмийн ялгаварлан гадуурхалт нь орлогын тэгш бус байдал эсвэл боловсролын боломжоос үүдэлтэй

11. Сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт /Сургуулийн сурагчид үе тэнгийнхнийхээ дунд бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж буй хандлага/

Хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтыг авч үзвээс хамгийн энгийн жишээ бол иргэдийг ажилд авахад буюу ажлын байрны орон тоо зарлагдахаас эхэлж байна. Энэ нь ажилтныг ажилд авахдаа тухайн ажлын байрны онцлогт хамааралгүйгээр хэт хувийн шинжтэй шалгуур үзүүлэлтүүдийг тавих, зарим нэг мэдээллүүдийг шаардах зэргээр илэрдэг<sup>11</sup>.

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Хөдөлмөрийн харилцааны ялгаварлал, гадуурхлыг хориглосон зүйл байдаг<sup>12</sup>. Энэ зүйлд ажил олгогч ажилтныг ялгаварлан гадуурхах, давуу байдал тогтоох, хязгаарлал бий болгохгүй байх үндэслэлүүдийг заасан байдаг<sup>13</sup>.

Тухайлбал:

- Хөдөлмөрийн харилцаанд үндэс угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.
- Ажил олгогч нь иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил үүргийн онцлог шаардлагын улмаас ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол энэ тухай үндэслэлээ нотлох үүрэгтэй.
- Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй... гэж заасан байдаг.

<sup>11</sup> Монгол улсын их хурлын цахим сайт. <https://www.parliament.mn/>

<sup>12</sup> Хөдөлмөрийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2021. 7 дугаар зүйл

<sup>13</sup> Монгол өмгөөлөгч хууль зүйн фирмийн цахим сайт. <https://advocate.mn/news/119/single/158>

Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэлийг ногдуулах ба шүүгч хуульд заасан торгууль ногдуулж хариуцлага хүлээлгэнэ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал тогтоохыг хориглох тухай заалтыг Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулиар баталгаажуулсан байдаг<sup>14</sup>.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд<sup>15</sup> Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааг хангах талаар зохицуулсан тусгай зүйл байдаг ба түүнд:

- Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендерээр ялгаварлан гадуурхах ба Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно.
- Талууд хамтын гэрээ, хэлэлцээрт эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, мэргэжлийн эрх ашиг, гэр бүлийн үүргээ хослуулах, хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах, түүнчлэн ижил ажилд адил цалин, нэмэгдэл хөлс тогтоох, ижил нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгана.
- Мөн ажил олгогчийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар хүлээх үүрэг, ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаар авах арга хэмжээ, ажилтны жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар эдлэх эрх, үүргийг зохицуулсан байдаг.

Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэлийг шүүгч ногдуулдаг ба эрх нь зөрчигдсөн этгээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисст гомдол гаргаж шийдвэрлүүлэхээр заасан байдаг байна<sup>16</sup>.

Хүний эрхийн Үндэсний Комисст ирсэн гомдол, мэдээлэл, мөн тус Комиссоос хийсэн судалгаануудыг нэгтгэн дүгнэхэд хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт их байдаг болохыг хэлээд холбогдох тайлбар, мэдээллийг өгсөн. Цаашид энэ төрлийн гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх механизм бүрдүүлэхэд төвлөрч анхаарах шаардлагатай гэдэг саналыг танилцуулсан. Хэдийгээр хууль тогтоомжид тодорхой хэмжээгээр тусган, зохицуулсан ч 2017 оноос хойш хоёр удаа энэ төрлийн гомдлоор хэрэг нээсэн, гэхдээ нэг ч хэргийг шийдвэрлээгүй. Учир нь бодит хохирол шаарддаг, харин энэ төрлийн үйлдэл хэлбэрийн төдий бүрэлдэхүүнтэй биш учир гэмт хэргийн зүйлчлэлийн улмаас шийдэгдсэн тохиолдол байдаггүй аж.

Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд 2021 оны хуулиар ялгаварлан гадуурхахгүй гэж тусгаснаас хойш энэ төрлийн гомдол эрс нэмэгдсэн болохыг дурдаад

<sup>14</sup> Хөдөлмөрийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2021. №31. 7 дугаар зүйл

<sup>15</sup> Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2011. №8.

<sup>16</sup> Монгол өмгөөлөгч хууль зүйн фирмийн цахим сайт. <https://advocate.mn/news/119/single/158>

эдийн болон эдийн бус харилцаа, иргэний харилцаа, төрөөс үйлчилгээ авахтай холбоотой ялгаварлан гадуурхалтын асуудал олонтоо хөндөгддөг гэлээ. Иймд ялгаварлан гадуурхалт мөн эсэхийг тогтоох, шүүхийн бус журмаар шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх, нэгэнт тогтоогдсон тохиолдолд үргэлжлүүлэн шийдэх процессыг тодорхой болгох шаардлагатай гэдэг санал танилцуулсан.

Монгол Улсад ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль тогтоомж бий хэдий ч бодит байдал дээр ялгаварлан гадуурхалт байсаар байгааг Комиссын дарга Д.Сүнжид тэмдэглэв. Энэ төрлийн гомдол байнга ирдэг бөгөөд гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх механизмыг бий болгох, зохицуулах хэрэгцээ шаардлага тулгамдсан болохыг илтгэлийнхээ төгсгөлд хэлсэн<sup>17</sup>.

### **Дөрөв. Ялгаварлан гадуурхалт ба сэтгэл зүйн эрүүл мэндийн шалтгаант холбоо**

Хүний эрхийн дэд хорооны дарга илтгэлдээ сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2016-2025 оны эхний хагас жилийн байдлаарх ялгаварлан гадуурхалт үйлдэгдэж буй нөхцөл байдлын талаарх тоо баримтыг танилцуулсан<sup>18</sup>.

*“Тухайн хугацаанд эрх бүхий байгууллагад ялгаварлан гадуурхалтад өртсөн гэх гомдол, мэдээлэл 186 бүртгэгджээ. Тодруулбал, үндэс, угсаагаар ялгаварлан гадуурхагдсан гэх 15, хэл, зан заншлаар ялгаварлан гадуурхагдсан гэх 2, насаар ялгаварлан гадуурхагдсан гэх 12, хүйсээр ялгаварлан гадуурхагдсан гэх 7, нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхагдсан гэх 5, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхагдсан гэх 77, хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхагдсан гэх 4, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхагдсан гэх 30 гомдол мэдээлэл бүртгэгджээ. Мөн шашин шүтлэгийн улмаас ялгаварлан гадуурхагдсан гэх 2, үзэл бодол, боловсролын түвшинээс үүдсэн ялгаварлан гадуурхалтад өртсөн гэх 28 гомдол, мэдээлэл бүртгүүлсэн байна. Эдгээрээс 1 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэдий ч хэрэгсэхгүй болгосон байна”.* Монгол Улсад ялгаварлан гадуурхалтын хэргийг шийдэж байгаагүй гэдгийг дээрх баримт илэрхийлж байгаа аж<sup>19</sup>.

Иймд олон улсын жишгийн дагуу, хүний үндсэн эрхийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэх нь зохистой талаар иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, олон нийттэй зөвшилцөх шаардлага үүсэн байна.

Ялгаварлан гадуурхах хандлага нь хүний үндсэн эрхэд халддаг бөгөөд хүнийг ямар нэгэн нийгмийн бүлэгт харьяалагддагийнх нь төлөө ялгаварлан гадуурхах, түүнийгээ туйлширсан байдлаар илэрхийлж буй үйлдэл Монгол Улсад түгээмэл байгааг судалгаа харуулж байна. Иймд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар: “Цөөнхийн эрхийг хамгаалах: Ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хууль тогтоомж боловсруулах практик гарын авлага”-ыг боловсруулж, НҮБ-ын гишүүн орнуудыг тус гарын авлагын дагуу ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц зохицуулалт бүхий хууль тогтоомжтой болох зөвлөмж гаргасан байна. Бие даасан хуультай болсноор ялгаварлан

<sup>17</sup> Монгол улсын их хурлын цахим сайт. <https://www.parliament.mn/>

<sup>18</sup> Монгол улсын их хурлын цахим сайт. <https://www.parliament.mn/>

<sup>19</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа”, Уб., 2019

гадуурхалтын ойлголт, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийн ойлголт, хамрах хүрээ, хуулиар заавал авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, хууль зөрчигчид хүлээх хариуцлага, хохирогчийг хамгаалах, хохирлыг барагдуулах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх асуудал, гомдол гаргах болон гомдлыг шийдвэрлэх ажиллагаа, нотлох баримтыг үнэлэх асуудал, хуулийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдүүдийн чиг үүрэг, бүрэн эрх, хариуцлагын тухай зэрэг асуудлыг тодорхойлох ач холбогдолтой бөгөөд хэрэгжилт, ухамсар соёл бүрдэх боломжтой гэж үзсэн байна.

Ялгаварлан гадуурхалт нь хүний сэтгэл зүй болон биеийн эрүүл мэндэд хүчтэй нөлөө үзүүлдэг болохыг *Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгийн* судалгаагаар тогтоожээ<sup>20</sup>. Хүн өөрийгөө ялгаварлагдаж болзошгүй гэж мэдрэхэд ч гэсэн стрессийн хариу урвал идэвхжиж, сэтгэлзүйн дарамт бий болдог байна. Энэ нь бодит ялгаварлал тохиолдоогүй байсан ч айдас, сэрэмж, түгшүүрийг байнга мэдрэх шалтгаан болдог. Ийм төрлийн байнгын сэрэмжтэй байдал нь хүнийг тайван бус болгож, сэтгэлзүйн тогтворгүй байдалд хүргэдэг<sup>21</sup>.

Өдөр тутмын амьдралд ялгаварлан гадуурхалттай тулгарч буй хүмүүс өөрсдийгөө хамгаалах зорилгоор зан үйлээ өөрчлөх хандлагатай байдаг. Жишээлбэл, уугуул америкчуудын 43 хувь нь ялгаварлагдахгүйн тулд юу хэлэх, яаж хэлэхдээ анхаарч, тодорхой нөхцөл байдлаас зайлсхийдэг гэжээ. Харин хар болон испани гаралтай хүмүүсийн 30 орчим хувь нь үйлчилгээ авахдаа доромжлол, үл хүндэтгэлтэй хандлагад өртөхөөс сэргийлж гадаад төрх, хувцаслалтаа илүү анхаарах болсон байна. Зарим хүмүүс бүр гэрээс гарахаасаа өмнө бусдын доромжлол, үл тоомсорлолд сэтгэлзүйн бэлтгэл хийдэг гэж хариулсан нь ялгаварлан гадуурхалт хэр гүн гүнзгий нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Судалгааны дүнгээр ялгаварлагдсан хүмүүсийн дундаж стрессийн түвшин 10 онооны шатлалаар 6 орчим байхад, ялгаварлагдаагүй хүмүүсийнх 4–5 орчим байсан нь ялгаварлан гадуурхалт стрессийн түвшинг бодитоор нэмэгдүүлдэг болохыг нотолжээ. Энэ зүй тогтол нь арьс өнгө, хүйс, нас, бэлгийн чиг баримжаа зэрэг бүх бүлэгт ажиглагдсан. Ялгаварлан гадуурхалт нь зөвхөн сэтгэл зүйд бус, биеийн эрүүл мэндэд ч сөрөг нөлөөтэй байдаг. Судалгаагаар ялгаварлагдаагүй хүмүүсийн 45 хувь нь эрүүл мэндээ “маш сайн” гэж үнэлсэн бол ялгаварлагдсан хүмүүсийн дунд энэ үзүүлэлт 31 хувь болж буурсан байна. Энэ ялгаа бүх арьс өнгө, үндэстний бүлэгт илэрсэн нь ялгаварлан гадуурхалт эрүүл мэндийн чанарыг нийтэд нь бууруулж буйг харуулж байна.

Насны бүлгээр авч үзвэл ахмад үеийнхэн ялгаварлалтай харьцангуй сайн зохицож чаддаг бол залуус илүү эмзэг, стресст өртөмтгий байдаг. Baby boomer болон mature үеийн хүмүүсийн 60 гаруй хувь нь ялгаварлалтай “сайн зохицсон” гэж хариулсан бол миллениал болон Generation X үеийнхэн дунд энэ үзүүлэлт 50 орчим хувьтай байжээ. Мөн LGBT хүмүүсийн дунд ялгаварлалтай зохицож чадсан гэж үзэх хувь 40 орчим байгаа нь бусад бүлгээс доогуур байна.

<sup>20</sup> *Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгийн цахим сайт. <https://www.apa.org/>*

<sup>21</sup> Б.Батсайхан “Сэтгэл судлалын үндэс”, Уб., 2013 он, хуудас 12

Харин сэтгэлзүйн болон нийгмийн дэмжлэгтэй байх нь ялгаварлан гадуурхалтын сөрөг нөлөөг зөөлрүүлдэг гол хүчин зүйл болохыг судалгаа харуулсан. Ялгаварлалтай тулгарсан боловч сэтгэлзүйн дэмжлэгтэй байсан хүмүүсийн 65 хувь нь “сайн зохицсон” гэж үзсэн бол дэмжлэггүй хүмүүсийнх ердөө 37 хувь байжээ. Мөн сэтгэлзүйн дэмжлэггүй хүмүүсийн стрессийн дундаж түвшин 6.3 байсан бол дэмжлэгтэй хүмүүсийнх 5.0 болж буурсан байна. Энэ ялгаа бүх арьс өнгөний бүлгүүдэд ижил хандлагатай байсан бөгөөд цагаан арьст дунд сэтгэлзүйн дэмжлэгтэй хүмүүсийн 69 хувь нь сайн зохицсон гэж хариулсан бол дэмжлэггүй хүмүүсийнх 36 хувь байсан. Хар арьстнуудын хувьд энэ үзүүлэлт 63 болон 30 хувь, испани гаралтай хүмүүсийн хувьд 54 болон 38 хувь байсан байна<sup>22</sup>.

Эдгээр үр дүнгээс харахад ялгаварлан гадуурхалт нь хүний сэтгэл зүй, зан үйлийг гүнзгий өөрчилж, стрессийн түвшинг нэмэгдүүлэн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг тодорхой хүчин зүйл гэдэг нь нотлогдож байна. Гэхдээ нийгмийн болон сэтгэлзүйн дэмжлэгтэй хүмүүс илүү тэсвэртэй, нөхцөл байдлыг даван туулах чадвартай байдаг нь хүний орчны дэмжлэгийн чухлыг онцлон харуулж байна.

**Ажлын байран дахь үл тоомсорлолыг авч үзвэл:** Ялгаварлан гадуурхалт нь хохирогчид сэтгэл зүйн өвдөлт, бухимдал төрүүлж, тэдний үндсэн сэтгэлзүйн хэрэгцээг доройтуулах замаар “нийгмийн үхэл” мэт мэдрэмж төрүүлдэг. Хүмүүс өөрсдийгөө үл тоомсорлуулж байна гэж хүлээн авбал өвдөлт мэдэрч, бусад хүмүүс болон байгууллагынхаа талаар сөрөг хандлагатай болдог. Үл тоомсорлол нь бусдаас тусгаарлагдсан мэдрэмж төрүүлж, хамт олондоо хамааралтай байх мэдрэмжийг нь алдагдуулдаг<sup>23</sup>. Мөн энэ нь ихэвчлэн чимээгүй, нууц байдлаар илэрдэг тул хувь хүний байгууллагын гишүүн гэсэн үнэ цэнийг бууруулж, байгууллагатайгаа өөрийгөө ижилсүүлэх сэтгэл хандлагыг сулруулдаг. Үүнээс гадна, үл тоомсорлол нь хүний хувийн нөөцийг шавхах тул хохирогч өөрийн үлдсэн нөөцийг хамгаалахын тулд байгууллагад үлдэх сэдлээ бууруулах буюу ажлаасаа гарах хандлагатай болдог<sup>24</sup>.

Ажлын байран дахь үл тоомсорлол нь хүний зан төлөвт сөрөг болон эерэг аль аль нөлөөг үзүүлж болдог. Зарим тохиолдолд үл тоомсорлогдсон хүмүүс дахин хүлээн зөвшөөрөгдөхийн тулд байгууллагад ашигтай зан үйлийг (жишээ нь сайн дурын ажил, тусламж) илүү үзүүлж болох ч, тэд нийгмийн хувьд илүү эмзэг болж, бусдын нөлөөнд автамтгай болдог. Гэвч ихэнх судалгаагаар үл тоомсорлол нь хохирогчийн сэтгэлзүйн хэрэгцээг зөрчиж, сөрөг зан авир үүсгэдэг болохыг харуулдаг.

“Нүдний хариуг нүдээр” гэсэн сэтгэлзүйн хандлагын дагуу, үл тоомсорлол нь хариу өш хонзонгийн зан төлөвийг өдөөж, байгууллага эсвэл хувь хүмүүст чиглэсэн хазайсан (deviant) зан үйлийг бий болгож болдог. Ийм зан үйл нь байгууллагын эсрэг (жишээ нь тоног төхөөрөмжийг эвдэх, орчныг бохирдуулах) эсвэл хамт олны эсрэг (жишээ нь цуурхал тараах, зөрчил үүсгэх) хэлбэрээр илэрдэг. Мөн “сайн хандлагад сайн, муу хандлагад муу” гэсэн харилцан үйлчлэлийн зарчмын дагуу, үл тоомсорлогдсон хүмүүс байгууллагад үзүүлэх эерэг зан үйлээ бууруулдаг. Тэд байгууллагаас хөндийрч,

<sup>22</sup> Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгийн цахим сайт. <https://www.apa.org/>

<sup>23</sup> Н.Оюундалай “Байгууллагын сэтгэл судлал”. Уб., 2017 он, хуудас 45

<sup>24</sup> <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/>

ажил гүйцэтгэл болон байгууллагын сайн дурын зан үйлийг багасгадаг. Хэрэв хүн байгууллагаасаа дэмжлэг авч чадахгүй гэж үзвэл байгууллагын сайн дурын зан үйлийг бууруулдаг бол, хамт олонтойгоо эерэг харилцаа тогтоох боломжгүй бол хувь хүний сайн дурын зан үйлийг бууруулдаг байна<sup>25</sup>.

#### **Тав. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал**

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар "Иргэний болон улс төрийн эрхийн тухай", "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай" олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн. НҮБ-ын гишүүн 190 гаруй орноос ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтыг судлан үзвэл /Хавсралт 4-өөс үзнэ үү./26 тусгайлсан хуультай 18 орон байна. Эдгээр улсуудаас Европын Холбоо, ИБУИНВУ, ХБНГУ, Австрали Улс, АНУ болон Колумба Улсын алагчлах үзлийг хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсон талаар 8-9 нийтлэг шинжээр алагчлах үзэл гаргах явдлыг хориглосон байна. Эдгээр шинжүүдийг хуулийн зорилго болгон тусгасан байх боловч ихэнх тохиолдолд нийтлэг харилцаанд авч үзжээ.

*Нэг. Европын Холбоо:* Европын Холбооны гишүүн орон "Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль" тэр дундаа "Арьс өнгөөр тэгш байх зааварчилгаа"-нд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гадаадын иргэдээс айх үзэл, үзэн ядах гэмт хэргийн эсрэг зэрэг асуудлыг авч үздэг байна. Энэхүү хууль зүйн баримт бичиг нь олон салбарт үйлчилдэг. Тухайлбал, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал болон нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ, мөн нийгмийн давуу эрх, боловсролын үйлчилгээ, шашин шүтэх, ажил олгох, мэргэжил эзэмшихэд нь ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг өргөн хүрээнд зохицуулагддаг.

Европын Холбоо нь олон нийтийг хамарсан, хүчирхийлэлд өдөөн турхирсан үйлдлийг гэмт хэрэгт тооцон шийтгэл ногдуулах талаар, эрүүгийн хууль тогтоомжид хуульчлахыг зөвлөмж болгосон. Энэхүү баримт бичиг нь гишүүн орнуудад үл ялгаварлах, тэгш хандах үүрэг хүлээсэн бөгөөд тус холбоо нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хамгаалалтад авах журам боловсруулсан байна.

Европын Комисс нь яг тодорхой асуудлаар санаачилга /цахим сүлжээн дэх хууль бус үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, менежментийн асуудлыг дэлгэрүүлэх г.м/ гаргаж, эрх бүхий байгууллага, иргэний нийгэмд зориулсан төслийн санхүүжилтийн санг байгуулан Эрх тэгш байдал болон Иргэний хөтөлбөр боловсруулсан байна. Энэ хөтөлбөр нь шашны болон цөөнхийн бүлэглэлд байгаа хүмүүсийг хамгаалах асуудлыг зохицуулсан байх бөгөөд тэр дундаа Европын Комиссоос томилогдсон Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, мөн Муслам шашинтай иргэдийг үзэн ядахтай тэмцэхэд чиглэгджээ. Европ дахь шинэ, хуучин Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, тэдний нөхцөл байдлын талаар олж мэдэх зорилгоор 2018 оны 12 дугаар сард 23/78

---

<sup>25</sup> <https://pmc.ncbi.nlm.nih.gov/>

"Жүүдүүдийн эсрэг үзлийн тухай" судалгааг Европын Холбооны Хүний эрхийн агентлаг явуулсан байдаг<sup>26</sup>.

Европын Комисс нь бүх хүмүүсийн тэгш эрхийг хангах, тэр дундаа Европын Холбоон дахь Африк гаралтай иргэдийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудалд тусгайлан анхаарал хандуулдаг байна. Ийнхүү "Afrophobia" гэх нэр томъёог тусгайлан судалж, хэлэлцүүлэг зохион байгуулж ихээхэн хүчин чармайлт гаргасны үр дүнд Европын Комиссоос гаргасан төслийн баримт бичигт тусгалаа олж, улмаар 2018 оны 5 дугаар сарын 14-17-ны хооронд Европын Парламентаас зохион байгуулсан "Европын Холбоо Африк гаралтай иргэдийн 7 хоног" гэсэн чуулганаар хэлэлцэгдэн, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилготой дүгнэлтэд тусгалаа олсон байна.

*Хоёр. ХБНГУ:* ХБНГУ-д аливаа хэлбэрээр алагчлах үзлийг хориглосон бөгөөд Европын Холбооноос гаргасан Алагчлах үзлийн эсрэг 4 зааварчилгааг өөртөө нэгтгэсэн. 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдөр "Тэгш хандах тухай ерөнхий хууль"-ийг батлан гаргасан.

Тус хуулийн зорилго нь дараах нийтлэг долоон шинж болох арьс өнгө, гарал үүсэл, угсаа язгуур/, хүйс, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, хөгжлийн бэрхшээл, нас болон бэлгийн чиг хандлагын улмаас хуулиар зохицуулсан харилцаанд ялгаварлан гадуурхах явдлаас хамгаалахад чиглэсэн байна. Эдгээр шинж бүрээр ялгаварлан гадуурхаж болохгүй тохиолдлуудыг заан тодорхойлсон. Үүнээс гадна хуулийн 20 дугаар зүйлд алагчлах үзэл гаргахыг зөвшөөрсөн нөхцөлийг хуульчилжээ. Үүнд:

- аюул заналхийллээс зайлсхийх болон, гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэхэд, эсхүл харьцуулсан шинж бүхий бусад зорилгоор;
- хувь хүний халдашгүй болон аюулгүй байдлыг хамгаалах шаардлагыг хангахаар бол;
- тусгай тэтгэмж бүхий давуу байдал олгох болон тэгш хандахыг албадах ашиг сонирхол үгүй бол;
- эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн шашин болон шашин шүтэх эрх, эрх чөлөө эсхүл шашны нийгэмлэгийн өөртөө засан тохинох эрхээ эдлэх зорилгоор болон тэдгээрт зориулсан (хууль зүйн хэлбэрийг үл үл харгалзан) байгууламж болон хамтдаа шашин шүтэх, эсхүл тэдний хүндэтгэж буй үзэл санаа, итгэл үнэмшилтэй байхад нь зориулсан байгууллагад нэгдэх нь зөвтгөгдсөн үед шашин, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлага, эсхүл хүйсээр алагчлах нь зорилго бүхий үндэслэлтэй байвал алагчилсан гэж үзэхгүй.." гэж заасан байдаг.

*Гурав. Австрали Улс:* Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомж нь холбооны болон муж улсын түвшинд үйлчлэх бөгөөд олон нийтийн дунд ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхээс хамгаалахад чиглэсэн байдаг. Холбооны хууль нь муж улсын нутаг дэвсгэрийн хуулиудтай нэгэн зэрэг үйлчлэх хүчин чадалтай байдаг.

<sup>26</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн. Ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа. Уб., 2019

Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг Австралийн Хүний Эрхийн Комиссын тухай хууль (1986), Шударга ажлын тухай хууль (2009)-ийг гол хууль болгон авч үздэг бөгөөд Насаар алагчлахгүй байх тухай хууль (2004), Хөгжлийн бэрхшээлээр алагчлахгүй байх тухай хууль (1992), Арьс өнгөөр алагчлахгүй байх тухай хууль (1975), Хүйсээр алагчлахгүй байх тухай хууль (1984) гэсэн 6 хуулийг Холбооны хэмжээнд дагаж мөрддөг байна<sup>27</sup>.

*Ялгаварлан гадуурхалтын талаарх бодит кейс*

Өнөө цагт өсвөр насны сурагчид буюу 14-16 насныхан нэгнээ өмссөн пүүзээр нь ялгаварлан гадуурхдаг болжээ. Анги танхим, дугуйлан, секцэд өмссөн хувцас тэр дундаа өмссөн пүүзээр нь эрэмбэлэн жагсааж ялгаварладаг болсон байна<sup>28</sup>.

Энэхүү ялгаварлан гадуурхалтад өртсөн сурагчдын кейс болон сургуулийн багш, сэтгэлзүйч нартай хийсэн ярилцлага, сурвалжилгыг та бүхэнд хүргэж байна.

**Кейс 1.** "Би ... сургуулийн есдүгээр ангид суралцдаг. Сургуулийнхаа сагсан бөмбөгийн шигшээд байдаг. Сагсан бөмбөгийн бэлтгэл байнга хийдэг болохоор зааланд өмсдөг пүүз хамгийн чухал. Гэвч заримдаа өмсөж байгаа пүүз нь нэр төрийн баталгаа болдог.

Сагсны шигшээ үе дотроо бэлтгэл хийдэг, өнгөрсөн жилээс эхлээд миний пүүзийг чанаргүй, хулхи гэж голоод дээрэлхэж эхэлсэн. Миний пүүзийг шаланд чахруулж дуугаргаж үзнэ, базна, тэгээд хулхи байвал бөөнөөрөө гадуурхаж эхэлнэ.

Намайг дөхөөд очихоор л "Нөгөө хямдхан бацаан ирж байна, явъя" гэдэг. Хэдий насаар чацуу ч гэсэн шоглоом хийж байгаа маягаар бацаан аа, хүүхэд ээ, хүүе хулхи аа гэж дууддаг. Эхэндээ энэ байдлыг тэсээд гарчихна гэж бодсон. Гэхдээ удах тусам сургуульдаа, хичээлдээ, секцдээ явах хүсэлгүй болж эхэлсэн".

*Өсвөр насныхан нэгнийхээ пүүзний оригинал эсвэл "хулхи"-ийг юүтүб болон рийл бичлэг дээрх зөвлөмжийг ашиглан шалгадаг. Пүүзийг мушгиад үзэхэд ул нь бамбалзаж байгаа эсэхээр нь оригинал болох хулхийг нь ялгадаг жишиг тогтжээ.*

**Кейс 2.** "Би ... дүүргийн ... сургуулийн 10а ангид сурдаг. Би ангидаа таван хүүхэдтэй нийлдэг байсан юм. Сүүлд нь манай ангид нэг эрэгтэй хүүхэд шилжиж ирснээс хойш миний өмссөн хувцсыг шүүмжилж эхэлсэн.

Би нэг пүүзээ их удаан өмссөн. Үнэндээ би пүүзээ маш цэвэрхэн гамтай арчилж өмсдөг. Гэтэл нийлдэг найзуудаас маань нэг нь надаас "Танайх ядуу болохоор чамд өөр пүүз байдаггүй юм уу" гэсэн. Найзаасаа ийм үг сонсоно гэж огт бодоогүй, сонсоод чихэндээ ч итгээгүй, юу гэж хариулахаа мэдэхгүй хий дэмий л урдаас нь инээгээд зогсож байсан.

Бага багаар найзууд маань надаас зайгаа барьж эхэлсэн. Намайг явсны дараа тэд цугладаг болж, байхгүйд хөгжилдөж, дөхөөд очихоор л царай нь хувьсхийдэг байсан. Ангид сууж байхад толгой руу тоглоомоор цохино, босох үед дэгээдэж унагаана, заримдаа цүнх нуучихсан байдаг байсан.

<sup>27</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн. Ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа. Уб., 2019

<sup>28</sup> <https://eguur.mn/>

Энэ байдал надад үнэхээр хэцүү санагдаж эхэлсэн учраас аав ээж хоёроосоо гуйж байгаад өөр сургууль руу шилжсэн. Одоо шинэ сургуульд маань хуучин сургуулийнх шиг асуудал байхгүй учраас сэтгэл их амар тайван байгаа.

Надад шоолуулж, шоглуулах хамгийн дарамттай байсан. Яг юу гэж илэрхийлэхээ мэдэхгүй байна. Ямар ч байсан үхмээр санагддаг байсан" гэж эх сурвалж маань нэмэлтээр өгүүллээ<sup>29</sup>.

*14-16 насныхан 500 мянгаас дээш үнэлгээтэй пүүзийг илүүд үздэг. Гадаадын болон дотоодын инфлюенсерүүдийг дуурайх үзэгдэл элбэг байдаг бөгөөд аав, ээжээрээ үнэтэй пүүз авхуулахыг гуйдаг байна. Хүүхдүүд тухайн жилдээ гарсан шинэ загварын пүүзнүүдийг авах сонирхолтой байдаг ба заримд нь оригиналь л пүүз байвал үйлдвэрлэгдсэн он нь хамаагүй гэх хандлага түгээмэл байдаг байна.*

#### **4. Дүгнэлт**

Нийгмийн ялгаварлан гадуурхалт нь хувь хүний сэтгэлзүй, нийгмийн оролцоо, сэтгэлзүйн эрүүл мэндэд гүнзгий сөрөг нөлөө үзүүлдэг цогц үзэгдэл болох нь судалгаагаар нотлогдож байна. Ялгаварлагдсан хүмүүсийн дунд стрессийн түвшин нэмэгдэх, сэтгэл гутрал, түгшүүр, ганцаардлын мэдрэмж ихсэх зэрэг сэтгэлзүйн өөрчлөлтүүд илүү түгээмэл ажиглагддаг бөгөөд энэ нь хувь хүний өөрийгөө үнэлэх чадвар, нийгмийн итгэлцэл, хамтын оршихуйн сэтгэлзүйг алдагдуулдаг.

Сэтгэлзүйн талаас авч үзвэл ялгаварлан гадуурхалт нь хүний нийгмийн хэрэгцээний үндсэн элемент болох хүлээн зөвшөөрөгдөх, харьяалагдах, аюулгүй байх мэдрэмжийг зөрчдөг тул гүнзгий дотоод дарамт үүсгэдэг. Үүнээс улбаалан хувь хүн өөрийгөө хамгаалах сэтгэлзүйн механизмуудыг идэвхжүүлж, нийгмээс тусгаарлах, хэт болгоомжлох, итгэл алдрах зэрэг зан үйлийн өөрчлөлт гаргах хандлагатай болдог. Гэсэн хэдий ч нийгмийн болон сэтгэлзүйн дэмжлэг, эерэг харилцаа, боловсролын хүртээмж зэрэг хүчин зүйлс ялгаварлан гадуурхалтын сөрөг нөлөөг бууруулах чухал хамгаалах хүчин зүйл болдог.

Хүүхдүүдийн дунд энэ мэт ялгаварлал социал ертөнц, инфлюенсерүүдийн “брэнд шүтэх” соёлын нөлөөгөөр улам газар авч байна. Үнэтэй пүүз өмсөх нь нэр төрийн хэрэг, харин хямдхан гутал өмсөх нь ичгэвтэр зүйл мэт ойлголт хүчээ авчээ. Гэвч энэ бүхэн ард нь “үнэ цэн нь пүүзээр бус, хүнээр хэмжигдэх ёстой” гэсэн жинхэнэ үнэнийг бүдгэрүүлж орхиж байна.

Өсвөр насныхан хамгийн эмзэг, сэтгэлзүйн хувьд өртөмтгий насандаа ийм ялгаварлалыг туулж буй нь хожмын амьдралд нь итгэлгүй, айдастай, өөрийгөө үнэлэх итгэлгүй хүн болон төлөвших эрсдэлтэй. Тиймээс сургууль, эцэг эх, нийгмийн зүгээс хүүхдүүдийн “брэндийн ялгаа”-г бус, бие биеэ хүндлэх, хайрлах, ойлгох зөрүүг арилгах хүмүүжил, үнэт зүйлд илүү анхаарах цаг иржээ.

Иймээс ялгаварлан гадуурхалт нь зөвхөн хүний эрхийн асуудал бус, харин нийгмийн сэтгэлзүйн тогтвортой байдал, сэтгэцийн эрүүл мэндийн салшгүй бүрэлдэхүүн болохыг тодорхойлох нь зүйтэй юм.

<sup>29</sup> <https://eguur.mn/>

## САНАЛ

1. Боловсролын түвшинд: ЕБС болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрх, ялгаварлан гадуурхалт, нийгмийн хүлцэл, сэтгэлзүйн эрүүл мэндийн боловсролыг системтэйгээр тусгах. Энэ нь ирээдүйн иргэдийн ёс зүй, хамтын ухамсар, хүлээцтэй байдлыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй.
2. Нийгмийн бодлогын түвшинд: Төр болон төрийн бус байгууллагууд ялгаварлан гадуурхалттай тэмцэх хууль эрх зүйн орчныг бэхжүүлэхийн зэрэгцээ сэтгэлзүйн дэмжлэгийн тогтолцоог (зөвлөгөө, сэргээн засах үйлчилгээ, нийгмийн ажилтны туслалцаа гэх мэт) өргөжүүлэх шаардлагатай.
3. Сэтгэлзүйн дэмжлэгийн түвшинд: Ялгаварлан гадуурхалтад өртсөн иргэдэд зориулсан нээлттэй зөвлөгөөний төв, цахим үйлчилгээ, сэтгэл заслын хөтөлбөрийг хөгжүүлж, мэргэжлийн сэтгэл судлаач, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх.
4. Хувь хүний түвшинд: Хүн бүр ялгаатай байдлыг ойлгож, бусдыг хүндэтгэх, өрөвдөх, эерэг харилцааг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай. Энэ нь ялгаварлан гадуурхалтыг бууруулах хамгийн үндсэн, үр дүнтэй соёлын өөрчлөлтийн үндэс болно.

## 5. Эх сурвалж

### Хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1. 14 дүгээр зүйл.
2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2011. №8.
3. Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. 2015. №07. 14 дүгээр зүйл
4. Хөдөлмөрийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2021. №31. 7, 111 дүгээр зүйл

### Ном, сурах бичиг

5. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017. 56, 194 дэх тал
6. Б.Батсайхан “Сэтгэл судлалын үндэс”, Уб., 2013он, хуудас 12
7. Ю.Бадамханд “Хүүхдийн эсрэг гэмт явдал”, Уб., 2014он, хуудас 32
8. Н.Оюундалай “Байгууллагын сэтгэл судлал”, Уб., 2017он, хуудас 45

### Гарын авлага, судалгааны тайлан

9. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа”, Уб., 2019
10. Улсын Их Хурлын даргын 2024 оны 89 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн “Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх” хэлэлцүүлэг., Уб., 2025

### Цахим эх сурвалж

11. Монгол улсын их хурлын цахим сайт. <https://www.parliament.mn/>
12. Монголын хуульчдын холбооны цахим сайт. <https://www.mglbar.mn/>
13. Монгол өмгөөлөгч хууль зүйн фирмийн цахим сайт. <https://advocate.mn/news/>
14. Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгийн цахим сайт. <https://www.apa.org/>
15. <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/>
16. <https://pmc.ncbi.nlm.nih.gov/>
17. <https://eguur.mn/>